

НИЙГМИЙН НЯГТРАЛЫН ТАЛААРХ СОЦИОЛОГИЙН ОНОЛЫН ТОЙМ

А. Долгион
IRIM судалгааны хүрээлэн
Ц. Болд

МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш

Нийгмийн нягтрал гэдгээр яг юуг ойлгож байна вэ? Нийгмийн нягтрал (social cohesion), эв нэгдлийг (solidarity) тус тусад нь тодорхойлж болох уу? Ялгаа нь юу вэ?

Энэ хоёр ойлголт хоорондоо маш ойрхон, давхцдаг. Ялгагдах шинж гэвэл эв нэгдэл гэдгээр илүү эерэг утга, эерэг функцийг авч үздэг, тухайлбал Э.Дюрхайм. Харин нийгмийн нягтралын гэдэг нь эерэг, сөрөг аль аль утгыг авчүздэг, үйл явц гэхээс илүүтэй нийгмийн төлөвийг тодорхойлдог ойлголт.

“Нийгмийн нягтрал” (social cohesion) гэдэг нь нийгмийн гишүүд, харилцааны бүх түвшинд, хамтын үр дүн болон зорилгод хүрэхийн тулд өөр хоорондоо хамтран ажилладаг байх, хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй байхыг хэлнэ” (Jeannotte et.al., 2002:3).

Нийгмийн нягтралыг судлах хэрэгцээ, шаардлага юу вэ?

Дэлхийн бусад улс орнуудын нэгэн адилаар Монгол дахь нийгмийн нягтралын асуудлыг судлах шаардлагатай болох талаар дор хаяж дараах үндэслэлийг хэлж болно.

Нэгдүгээрт, эдийн засгийн хөгжил болон нийгмийн хөгжлийн талаарх маргаан. Сүүлийн жилүүдэд хөгжингүй улс орнуудад эдийн засгийн бүтцийн өөрчлөлт эрчимтэй явагдсан, хөдөлмөрийн зах зээл уян хатан болсоор байгаа, худалдаа улам чөлөөлөгдсөөр байгаа, нийгмийн халамж багассан зэрэг нь нийгмийн олон асуудлыг шинээр бий болгож байна (Jeannotte 2000; OECD, 1997). Эдгээр нийгмийн асуудлуудыг тухайн үед ноёлож байсан эдийн засгийн онолоор, тухайлбал неолиберал онол, хандлагаар тайлбарлах боломжгүй юм гэдгийг олон эрдэмтэд хүлээн зөвшөөрөх болов (Allan and Rosenbluth, 1992, Stretton, 1999). Учир нь эдгээр хандлага нь нийгмийн харилцааны үүрэг ач холбогдол, нийгмийн үр дагаврын асуудалданхаарал хандуулдаггүй, нийгмийн хөгжлийг ДНБ-ээр хэмжихээс өөр аргаар хэмжих хэмжүүргүй, арга зүйн хувьд чадамжгүй гэж эдгээр шүүмжлэгчид үзэж байв. Нийгмийн тэгш байдал, хувь хүний сайн сайхан байдал, амьдралын чанар, эв нэгдэл, хамтын ажиллагаа, адилсал, соёлын хөгжил, нийгмийн шударга ёс, тэрчлэннийгмийн “амжилт” ба “доройтол” зэрэг нийгмийн нягтралд хамаарах асуудлуудыг нийгмийн шинжлэх ухааны парадигмаар судлах ёстой гэж үзсэн (Stanley, 1997; Stanley and Smeltzer, 1998).

Хоёрдугаарт, нийгэм, улс төр болон эдийн засгийн тогтолцоонд итгэх итгэл эрс буурч байна. Дэлхий даяар, ялангуяа Европ, Канад зэрэг хөгжингүй орнуудад, олон нийт ардчилсан тогтолцоо, улс төрд итгэх итгэл улам буурч, сэтгэл ханамжгүй болсон нь нийгмийн нягтралд сөргөөр нөлөөлөх болжээ. Тиймээс иргэдийн улс төрийн идэвх болон сонгуульд оролцох оролцоо огцом багасч, иргэд нийгмээсээ улам бүр хөндийрч, хүнийсэх болсон.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд болж буй олон нийтийн эсэргүүцэл, бослого хөдөлгөөнүүд, жишээлбэл “Арабын хавар”, АНУ дахь “Эзэлцгээе хөдөлгөөн”¹, Европд болж буй олон тооны эсэргүүцэл, үймээн самуун, Тайланд, Мексик дэх хөдөлгөөнүүд бүгд нийгэмд шударга ёсыг тогтоох гэсэн нэг л шаардлага тавьж байгаа. Дэлхий дахинд энгийн хүмүүс архаг ядуурал, тэгш бус байдал,

¹Эзэлцгээе хөдөлгөөн гэдэг нь олон улсын олон нийтийн эсэргүүцлийн хөдөлгөөн бөгөөд нийгэм, эдийн засгийн тэгш байдлын эсрэг тэмцдэг. Үндсэн зорилго нь эдийн засаг, улс төрийн харилцааг илүү хэвтээ, тэгш болгох юм. Тухайн улс орон бүрийн эзэлцгээе хөдөлгөөн өөр өөрийн шаардлага, шалтгаантай байдаг ч ихэнхидээ ардчиллын үнэ цэнийг алдагдуулж, цөөнхийн эрх ашигт үйлчилж, тогтворгүй байдлыг гааршуулж байгаа томоохон корпорациуд, дэлхийн санхүүгийн системийн эсрэг чиглэсэн байдаг /wikipedia/

шударга бус байдал, ажилгүйдэл, орон гэргүй байх, авлига зэрэг асуудлын өмнө улам бүр сөхөрч, эдгээр асуудлыг шийдвэрлэхийг хүсч байна.

АНУ-д нөхцөл байдал улам бүр хурцдаж байгааг Америкийн нэрт сэтгэгч Ноам Чомский хурцаар шүүмжилж “АНУ –д олон хүн горьдлого тасарч, олон нийтийн уур хилэн ихэсч байгаа бөгөөд үүнд засгийн газраас ямар ч арга хэмжээ авахгүй, хариу үйлдэл хийхгүй байна. Энэ янзаараа АНУ удахгүй маш түгшүүртэй байдалд хүрнэ” гэжээ.

Дээр хэлсэнчлэн, хэдийгээр хэлбэр цар хүрээний хувьд ялгаатай ч Монголд мөн адил эдгээр асуудлууд тохиолдож, шийдвэрлэх шаардлагатай асуудал болоод байна. Тодруулбал:

Нэгд, Монголд хийгдсэн зонхилох судалгаа нь (тухайн цаг үедээ төрийн бодлогыг тодорхойлоход нөлөөлсөн, суурь болсон судалгааг хамруулж ойлгосон) ихэвчлэн эдийн засгийн өнцгөөс хийгдсэн байдаг. Эдгээр судалгаа нь неолиберал болон бусад эдийн засгийн бодлогод суурилсан, эдийн засгийн өсөлтийг судалгааны гол судлах зүйл болгосон, мөн эдийн засгийн өсөлт нь нийгэм, соёлын зэрэг бусад салбарт эерэг үр дагаврыг аяндаа бий болгоно гэсэн үзэл суртал дээр тулгуурласан байна. Тухайлбал, хувийн секторын ач холбогдлын талаарх цуврал судалгаа, төрийн институтууд хүнд суртал, үр ашиггүй байдлыг багасгаснаар эдийн засгийг хэрхэн дэмжих талаар судалгаа, “Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг” (2005) зэргийг дурдаж болно (Дэлхийн банк ба Азийн хөгжлийн банк).

Гэтэл сүүлийн 10 жилд Монголын эдийн засаг тасралтгүй өсч байгаа ч нийгмийн хөгжилд мэдэгдэхүйц ахиц гарсангүй. Ёийгмийн тэгш бус байдлыг хэмждэг GINI коэффициент 1995 онтой (0,310) харьцуулахад 2012 оны байдлаар өссөн (0,44)² дүнтэй, ядуурлын индекс 27.3 хувьтай (2012) байна. Эдгээр индекс, үзүүлэлтийн цаана “...зарим ядуу иргэд өөрсдийгөө ядуу хэмээн тооцдоггүй тул ядуурлын бодит түвшин одоогоор тооцоологдсоноос ч өндөр гарах магадлалтай. Тухайлбал, хөдөө орон нутагт ундны цэвэр ус, эрүүл ахуйн боломж зарим тохиолдолд хязгаарлагдмал байдаг ч ихэнхи иргэд өөрсдийгөө ядуу хэмээн тодорхойлдоггүй бөгөөд энэ нь тэдний хувьд амьдралын наад захын хэрэгцээний талаарх ойлголт өөр байдагтай холбоотой” (UNDP 2012) зэрэг, маргаантай, тодруулах шаардлагатай олон асуудал бий. Тиймээс эдгээр ойлголтыг Монголын нийгмийн онцлогтой уялдуулан тайлбарлах, түүнчлэн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд эдийн засгийн өнцгөөс харсан гэхээс илүүтэй, нийгмийн харилцааны үүрэг, хүмүүсийн үзэл бодол, хандлага, үнэлэмж хэрхэн нөлөөлж байгааг судлах шаардлага үүссэн. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ядуурлын талаарх тайланд дурдсанаар:

Ядууралтай хийх тэмцлийг өрх гэрүүдээс гадна тодорхой бүлэгт чиглүүлэх нь илүү үр дүнтэй. Тухайн орон нутагт амьдарч буй иргэд нь ихэвчлэн нийтлэг шалтгааны улмаас ядууралд өртсөн байдаг тул тэр шалтгааныг нь онилж бүлгүүдийг дэмжсэнээр олон өрхийг нэгэн зэрэг ядуурлаас гаргах боломж байх магадлалтай.

Хоёрт, нийгмийн гишүүдийн дунд төрийн бодлого, нийгмийн хөгжилд итгэх итгэл, сэтгэл ханамж буурсаар байна. Энэ чиглэлээр хийгдсэн судалгаануудаас үзэхэд монголчууд бусад олон улс орны энгийн иргэдийн нэгэн адил тэгш бус байдал ихсэх, нийгмийн шударга ёс алдагдах, нийгмийн мобиль хөдөлгөөн царцах болсон хэмээн үзэж эгдүүцэж байна.

Энэ нь нэг талаас төрийн бодлого, үйл ажиллагаа нь нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглээгүй, тэгш бус байдлыг даамжруулсан гэж үзэж буй олон нийтийн сөрөг үнэлгээтэй холбоотой байх талтай. Тухайлбал, МУИС-ийн Социологи-Нийгмийн ажлын тэнхимийн судалгааны дүнгээс үзэхэд өнөөдрийн байдлаар төр засагт өгөх иргэдийн үнэлгээ хамгийн доогуур түвшинд байна. 40-өөс дээш хувь нь ЗГ (42,8%), УИХ (47,2%) –д муу гэсэн дүн тавьж байна. Түүнчлэн УИХ, ЗГ-ын үйл ажиллагааг сайн гэж үнэлсэн хувь (УИХ 4,1%, ЗГ 7,3%) тун ч бага, арван хувьд ч хүрэхгүй байгаа нь маш доогуур үнэлгээ болно (МУИС Социологи-Нийгмийн ажлын тэнхим 2013).

²<http://www.assa.mn/content/2312.shtml?a=economy>

Нөгөө талаас социологич Ц.Пүрэвийн бичсэнээр “нийгэмд хүмүүсийн үнэт зүйлс, эрхэмлэл, амьдралын зорилго нь хэрэгжихгүй болох, хэрэгжлээ ч гэсэн тухайн нийгэмд хүлээн зөвшөөрөгдөөгүй арга хэрэгслийг ашигладаг болох аваас нийгэмд гажуудал үүсдэг жамтай. Судалгаанаас үзэхэд өнөөдөр манайд материаллаг нөхцөлөө дээшлүүлэх талаар тавьж буй зорилгоо хэрэгжүүлж чадахгүй байгаа хүмүүс дийлэнх олонх болжээ” (Ц.Пүрэв 2013, 219).

Гуравт, Уул уурхайн салбарын өсөлттэй холбоотойгоор Монгол дахь дотоод ба гадаад шилжилт хөдөлгөөн сүүлийн 10 жилд нэмэгдсэн. Энэ нь нэг талаас тухайн орон нутагт оршин суугчдын амьдралын хэв маяг, нийгмийн харилцаанд нөлөөлөх, нөгөө талаас орон нутаг дахь институтууд (цагдаагийн байгууллага, эмнэлэг, сургууль гэх мэт) ба иргэдийн хоорондын харилцаа, итгэлцэлд нөлөөлж байдаг (IRIM and ADB 2012), (Shamit Saggar 2012).

Тиймээс эдгээр өдрөөс өдөрт өөрчлөгдөж буй эдийн засаг ба нийгмийн харилцаа, улс төр засгийн газрын институт ба иргэний хоорондын харилцаа, орон нутаг ба нийгмийн гишүүд хоорондын харилцааг ойлгох, тайлбарлах, түүнд тохирсон бодлогыг боловсруулахад нийгмийн нягтралын онолын үүрэг чухал юм.

Нийгмийн нягтарлын онол, парадигм

Сүүлийн хорин жилийн турш неолиберал парадигм буюу “*эдийн засгийн бодлого ямагт нийгмийн асуудлын өмнө тавигдах ёстой, учир нь зах зээл тэлж, өссөнөөр нийгмийн аливаа асуудал аяндаа шийдэгддэг*” (Rossabi 2005, 36) гэсэн үзэл дэлхий дахинд ноёрхож байв. Энэхүү парадигмыг аливаа нийгэм, хөгжлийн түвшинг тодорхойлох судалгаанд өргөн ашиглаж, эдгээр судалгаа нь нийтээр хүлээн зөвшөөрөгдөж ирсэн. (Broad 2006). Гэсэн хэдий ч 1990-ээд оноос дэлхийн олон улс оронд зэрэг эхэлсэн эдийн засаг, улс төрийн тогтолцооны огцом өөрчлөлт, даяаршил, нийгмийн халамжит төр³ хумигдах болсон зэрэг шалтгаан нь социал асуудлыг улам хурцатгах болов. Үүнд тэгш бус байдал, нийгмийн гадуурхал⁴, оршин буй системд итгэх итгэл буурах, нийтийн сэтгэл ханамж эрс доошлох, нийгмийн шударга бус байдал нэмэгдэх зэрэг дэлхий дахинд ба Монголд нийтлэг ажиглагдаж буй асуудлыг дурдаж болно (Stanley 2003, 7 and Dickes et. Al 2010).

Тиймээс “нийгмийн хөгжлийн асуудал бол зөвхөн эдийн засагчдын монополичилсон асуудал байх ёсгүй” (Gore 2000, 800), неолиберал парадигм нь “нийгмийн олон асуудлыг ойлгох, тайлбарлах, шийдвэрлэх чадамжгүй” гэсэн шүүмжлэл эрдэмтэн судлаачид болон шийдвэр гаргагчдын дунд гарах болов. Мөн “нийгмийн харилцан хамаарлыг тусгасан” судалгааны парадигмыг эрэлхийлж эхлэхэд хүргэв (Stanley 2003). Энэхүү эрэлт хэрэгцээг хангах үүднээс “нийгмийн нягтрал⁵” –ын талаарх онолын үзэл баримтлал нь улс төрийн болон нийгмийн шинжлэх ухааны хүрээнд эргэн ирж, эрчимтэйгээр хэрэглэгдэх боллоо. Үүнд социологичдын үүрэг онцгой давамгайлж байв. Тухайлбал, Э.Дюрхайм (1893)-ийн нийгмийн эв нэгдэл⁶ ба интеграцийн тухай ойлголт дээр тулгуурласан орчин үеийн социологичид болох Бергер⁷ (1998), Гидденс (1998), Гоф ба Олофсон (1999), Женсон (1999), Локвүүд (1999), Бернард (2000), Буувээ (2002), Фредкин (2004), Дюхэйм (2004) нар нийгмийн нягтралын талаарх өөр өөрийн онол, чиглэлийг боловсруулжээ.

Түүнчлэн нийгмийн асуудлаар томоохон судалгааны ажлуудыг санхүүжүүлж, хэрэгжүүлдэг Дэлхийн Банк, Европын Холбоо, НҮБ-ын харьяа байгууллагууд, Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (ОЕСД) зэрэг олон улсын байгууллагууд, мөн Канад, Франц, АНУ, Өмнөд Солонгос зэрэг хөгжингүй орнууд “нийгэм-соёлын хүчин зүйл нь эдийн засгийн хөгжил ба өсөлтөд нөлөөлөгч гол хүчин зүйл юм” гэсэн нийгмийн нягтралын парадигмыг судалгаандаа өргөнөөр

3 Welfare state

4exclusion

5social cohesion

6 solidarity

7Berger (1998), Giddens (1998), Gough and Olofsson (1999), Jenson (1999), Lockwood (1999), Bernard (2000), Beauvais (2002), Friedkin (2004) and Duhaime (2004).

ашиглаж байна (Ritzen et al., 2000 cited in Chan et al 2006). Нийгмийн нягтралын асуудлаар социологийн болон бодлогын шинжилгээний хүрээнд олон тооны ажлууд нийтлэгдсэн байна.

Энэхүү парадигмын гол шүүмжлэгчид, тухайлбал, Chan et al. (2006, 273) –ын хэлснээр “нийгмийн нягтрал” нь “даяаршил” гэдгийн адилаар улиг болтлоо хэрэглэгдсэн, онолын ач холбогдолгүй ойлголт байх магадлалтай. Түүнчлэн нийгмийн нягтралын онолын хүрээ, гол ойлголт нь өнөөг хүртэл тодорхойгүй, маш олон асуудлыг өөртөө агуулсан, зарим тохиолдолд өөр хоорондоо зөрчилтэй (жишээлбэл, Stanley 2003, Friedkin 2004, Chan et al., 2006, OECD 2011) хэвээр байна. Тиймээс нийгмийн нягтралын аль тодорхойлолтыг судалгаандаа хэрэглэж байгаагаас хамаарч “юуг шинжлэх, юуг хэмжих, ямар дүгнэлт гаргах” зэрэг нь маш ялгаатай байж болох (Beauvais and Jenson 2002, iii)эрсдэлтэй.

2.1 Нийгмийн нягтралыг тайлбарлах социологийн сонгодог онол

Нийгмийн нягтралын онол, хандлагыг ерөнхийд нь социологийн хандлага ба улс төрийн хандлага гэж хоёр хувааж болно(Chan et al. (2006). Социологийн хандлага нь нийгмийн эв нэгдэл, тогтвортой байдал, нийгмийн сүлжээ зэрэг ойлголтууд дээр голчлон тулгуурладаг (Dickes, Valentova and Borsenberger 2010, 453).

Эмиль Дюрхайм: Нийгмийн эв нэгдэл (1893)

Судлаачдын үзэж буйгаар нийгмийн нягтралын талаарх ойлголтын оюун санааны эцэг нь Эмиль Дюрхайм юм. Тэрээр аливаа нийгэм оршин тогтнох үндэс, нийгмийг нэг бүхэл зүйл болгож байдаг тэр зүйл юу вэ? гэсэн асуултыг тавьж байв. Тэрээр уг асуултын хариултад нийгмийн тогтвортой, статик байдал буюу нийгмийн эв нэгдлийн хангаж өгч байдгаараа хөдөлмөрийн хуваарь ач холбогдолтой гэж үзэж байв (О.Мөнхбат 2008, 63). Дюрхайм, орчин үеийн нийгмээс өмнөх нийгэмд нийгмийн нягтрал нь хүмүүсийн хоорондын ижил төстэй байдлаар нөхцөлддөг бөгөөд үүнийг механик эв нэгдэл гэж нэрлэж байв. Механик эв нэгдлийн үед нийгмийн гишүүд өөр хоорондоо гэхээс илүүтэй бүхэлнийгмээсээ хамааралтай байдаг аж.

Харин нийгэм аж үйлдвэржихийн хэрээр хөдөлмөрийн хуваарь улам нарийсч, хүмүүс өөр хоорондоо эсрэг тэсрэг шинжээр нөхцөлдсөн нийгмийн эв нэгдлийг бий болгож байдаг. Тэрээр үүнийг органик эв нэгдэл гэж нэрлэсэн бөгөөд энэ хэв шинж орчин үед давамгайлах болжээ. Органик эв нэгдэл гэдэг нь “хувь хүмүүс болон бүлгүүд өөр хоорондоо аливаа төрлийн солилцоо хийх системчлэгдсэн харилцаа бүхий харилцан хамаарлыг хэлнэ”. Нийгэмд олон янз байдал улам бүр нарийссанаар хувь хүмүүс урьд байгаагүй их эрх чөлөөтэй болно. Ингэснээр хөдөлмөрийн хуваарь нь зөвхөн эв нэгдлийг нөхцөлдүүлээд зогсохгүй хувь хүний индивидуалист байдлыг нэмэгдүүлдэг (Misztal 1996) ажээ.

Орчин үеийн олон төрөлт⁸ нийгмүүдэд хувь хүмүүсийн хоорондох ялгаа улам ихэссэнээр, нийгэмд өөрчлөлт хэт хурдацтай явагдаж улмаар нийгмийн амьдралыг зохицуулах нийтлэг хэм хэмжээ алдагдаж, төөрөгдөл үүсгэж, эцэстээ хэм хэмжээгүй, аномн нийгмийг бий болгох аюултай (Reeskens 2008, 9). Аноми гэдэг нь ёс зүйн аливаа хэм хэмжээ үгүй байгаагийн улмаас бий болсон зохицуулалтгүй хоосон орон зай мөн. “Капитализмын хөгжилтэй уялдан эдийн засгийн хүрээ нийгмийн амьдралд тун чухал байр суурь эзлэх болж, аж үйлдвэр, банк санхүүгийн эзэд улс орныг удирдахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болов. Урьдын нийгэмд хүн амын дийлэнх нь газар тариалан, мал аж ахуй зэрэг уламжлалт салбарт хөдөлмөрлөж байсан бол капиталист аж ахуйн үед хотжих үйл явц хурдасч, үйлдвэрт ажиллах хүмүүсийн тоо нэмэгдсэн. Энэ хэрээр эдийн засгийн хүрээний гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж, энд явагдаж буй үйл явц, социаль бүлгүүдийн зан үйл, харилцаа, нийгмийн амьдралд нөлөөлөх болсон авч тэдгээрийг зохицуулах хэм хэмжээ илт дутагдаж байгаа нь тун хортой үр дагавар юм” гэж Дюрхайм үзжээ (О.Мөнхбат 2008, 61). Түүнийхээр аномн байдлыг зохицуулах хэм хэмжээ бий болоогүй цагт, арьс өнгөөр ялгаварлах үзэл, гэмт хэрэг, амиа хорлолт гэх мэтнийгмийн гаж үзэгдэл газар авах болно.

⁸heterogeneous

Дюрхаймын үзлээр аноми байдлыг даван туулахад төрөөс баталсан аливаа хууль, тогтоол шууд хувь нэмэр оруулж чадахгүй. Учир нь тэдгээр эрх зүйн актууд нь ихээхэн нарийн төвөгтэй бүтэц бүхий нийгмийн бүлэг, гишүүд хоорондын харилцааг тусгасан хэм хэмжээг гаргах боломжгүй. Харин нийгмийн гишүүд хоорондын итгэлцэл, ёс суртахуунт байдал, хамтын ажиллагаа, солилцоо, мэргэжлийн бүлэг, сайн дурын холбоод зэрэг нь аномийг даван туулах зохицуулалтын функцийг хэрэгжүүлж чадна. Өөрөөр хэлбэл бие биенээсээ маш ялгаатай хувь хүмүүс зэрэгцэн амьдрахдаа бие биендээ итгэж, хамтран ажиллаж байх шаардлагатай аж. Гэсэн ч орчин үеийн нийгэм бүрт энэ итгэлцэл, харилцан хамаарал, хамтран ажиллах, ёс суртахуунт байдал бүрэн дэлгэрээгүй байдаг тул аноми байдал оршсоор байдаг.

2.2 Орчин үеийн социологичид нийгмийн нягтралыг тодорхойлсон нь

Хэдийгээр нийгмийн нягтралын талаар хангалттай хэмжээний бүтээл, судалгаа хийгдсэн ч өнөөг хүртэл нийгмийн нягтрал гэж юу болох, юуг хэмжих нь тодорхойгүй, нэгдсэн ойлголт бий болоогүй хэвээр байна (Jenson 1998; Jeannotte 2000; Osberg 2003). Зарим нэг нь нийгмийн нягтрал гэдгийг эв нэгдэл, итгэлцэл, нийгмийн капитал, ядуурал, тэгш бус байдал зэргээр ойлгодог бол зарим нь, ялангуяа социологичид уг ойлголтоор нийгмийн интеграци, системийн интеграцийг илэрхийлдэг (Gough and Olofsson, 1999). Үүнээс нийгмийн нягтрал гэдэг нь олон талт ойлголт болох нь тодорхой харагдаж байна. Тиймээс энэ хэсэгт нийгмийн нягтралын талаарх эдгээр олон талт тодорхойлолтыг авч үзэх болно.

Канадын нийгэм судлаачид: Жен Женсон (1998)

1998-2000 онуудад Канадын засгийн газрын “Нийгмийн нягтралын бодлогын судалгааны дэд зөвлөл”⁹-д суурилсан судлаачид нийгмийн нягтралыг хэмжих хэмжүүрүүдийг тодорхойлох, ойлголтыг нэгтгэх хүрээнд чамгүй судалгаа, бүтээл гаргасан байдаг. Тэдний гол төлөөлөгч болох Жен Женсон нь Дюрхайм, Токвиль нарын бүтээлийг судалж, тэдгээрт суурилан, мөн орчин үеийн онолуудтай холбосноор нийгмийн нягтралыг дараах байдлаар тодорхойлжээ:

“Нийгмийн нягтрал” (social cohesion) гэдэг нь нийгмийн гишүүд, харилцааны бүх түвшинд, хамтын үр дүн болон зорилгод хүрэхийн тулд өөр хоорондоо хамтран ажилладаг байх, хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй байхыг хэлнэ” (Jeannotte et al., 2002:3).

Жен Женсоны 1998 онд хэвлүүлсэн бүтээлд нийгмийн нягтралыг дараах таван тал¹⁰ бүхий ойлголтоор тодорхойлно гэж үзжээ.

Хүснэгт 1. Женсон: Нийгмийн нягтралын элементүүд

Түвшин	Нийгмийн нягтралын элементүүд	Тайлбар
Нийгэм	Нийгэмд хамаарах мэдрэмж/тусгаарлагдсан мэдрэмж – дундын үнэлэмжтэй байх	Дундын үнэлэмж, өөрийгөө нийгмийн гишүүн гэдгээ мэдрэх мэдрэмж – адилсал
	Хүлээн зөвшөөрөх/үгүйсгэх – олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх	Нийгэм дэх олон янз байдал, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүндлэх
Эдийн засаг	Нийгэмд inclusion/exclusion – эдийн засгийн институци нь хүн бүрт ижил тэгш хүртээмжтэй байх явдал.	Нийгмийн гишүүд зах зээл, эдийн засгийн хүрээнд оролцох боломж ижил тэгш байх
Улс төр	Оролцоо/оролцоогүй байдал – орон нутгийн түвшинд ардчилсан үйл явцад оролцож буй эсэх	Хүмүүсийн төв болон орон нутгийн түвшин дэх улс төрийн оролцоо

⁹ Policy Research Sub-committee on Social Cohesion of the Canadian Federal government

¹⁰ Belonging/isolation; participation/non-involvement; inclusion/exclusion; recognition/rejection; legitimacy/illegitimacy

	Хууль ёсны байдал/хууль ёсны бус байдал – институтууд хууль ёсны эсэх	Улс төр, нийгмийн гол институциуд хууль ёсны – нийгээр хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хүмүүсийн хоорондох харилцааны гүүр болж байдаг утгаараа
--	---	--

Женсоны нийгмийн нягтралын эдгээр үзүүлэлтүүд нь нийгмийн нягтрал ямар түвшинд байгааг хэмжих “continuum” болдог (Jenson, 1998:15 cited in Jeannotte 2008). Тэрээр, нийгмийн нягтралыг буюу нийгмийн гишүүдийн хамтран ажиллаж буй түвшинг нөхцөлдүүлж байдаг хэд хэдэн үзүүлэлт байдаг, төрийн бодлого, нийгмийн ба соёлын капитал, институци, үнэлэмж зэрэг нь чухал нөхцөлдүүлэгч хүчин зүйл болдог, хэмээжээ. Женсоны энэхүү загвараас үзэхэд үндсэн гурван төрлийн харилцаа байна (Jeannotte 2008, 4-5):

1. Нийгмийн нягтралын түвшин нэмэгдэх тусам улс төрийн хувьд илүү нийтийгхамарсан ба нийгмийн бодлого – боловсрол, эрүүл мэнд, даатгал, баялгийн шударга хуваарилалт зэрэгт чиглэсэн шийдвэрийг олон нийт дэмжих хандлагатай болдог. Эдгээр бодлого нь эргээд нийгмийн эерэг үр дагаврыг бий болгодог – ялангуяа бодлого нь бүгдийг хамруулсан байх тохиолдолд.
2. Нийгмийн нягтралын түвшин өндөр байх тусам нийгмийн гишүүдийн нийгмийн хэм хэмжээг дагаж мөрдөх, нийгэмд баримжаалсан үнэлэмжийг – итгэлцэл, хууль ёсыг дээдлэх, шударга байх гэх мэт – эрхэмлэх хандлагатай болдог. Ийнхүү институтууд хамтын ажиллагааны таатай орчинг нийгмийн гишүүдийн хувьд бүрдүүлж өгдөг – харилцаа нь эрсдэл багатай байснаар эдийн засаг, нийгмийн үр ашиг нэмэгдэнэ. Гэсэн хэдий ч бүх хэм хэмжээ нийгмийн нягтралыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байдаг гэж дүгнэх нь өрөөсгөл юм. Тиймээс нийгмийн нягтралыг дэмжээгүй үнэлэмж давамгайлж эхлэхэд нийгэм дэх итгэлцэл буурч аяндаа нийгмийн нягтрал саарах болно.
3. Нийгмийн нягтрал дээд түвшинд байх тусам иргэний нийгэм дэх оролцоо нэмэгдэнэ. Нийгмийн нягтрал, нийгмийн эерэг үр дагавар харилцан бие биендээ нөлөөлж тасралтгүй эргэх холбоог бий болгоно. Хэрэв энэ эргэх холбооны завсар хийдэл үүсвэл (тэгш бус байдлыг хөөрөгдсөн бодлого хэрэгжүүлэх гэх мэт) нийгмийн сөрөг үр дагавар бий болж энэ нь нийгмийн нягтралыг бууруулна.

Женсоны энэхүү онолын загварыг бусад судлаачид тайлбарлахдаа нийгмийн өнөөгийн асуудлууд “нийгмийн нягтралд” нөлөөлдөг гэсэн плюралистик хандлагын онол гэж үздэг. Олон ургальч гэдэг нь нийгмийн нягтралыг дараах таван чиглэлд авч судлах боломж олгодог:

1. Нийгмийн үнэлэмжийн хувьд
2. Нийгмийн хэв журам, хяналтын системийн хувьд
3. Нийгмийн нэгдмэл ёс¹¹, баялагийн тэгш хуваарилалтын хувьд
4. Нийгмийн сүлжээ, капиталын хувьд
5. Адилсал, хамаарлын¹² хувьд.

Женсон тэргүүтэй канадын судлаачдын томъёолсон онолын загвар, арга зүй нь ийнхүү олон талыг агуулсан, тухайн нийгэмд тухайн үед тулгамдаж буй асуудлыг харгалзах боломж олгодог тул монголын нийгмийг шинжлэхэд тохирохуйц онол байх боломжтой юм.

Чан ба түүний хамтран зүтгэгчид - Chan et.al (2006)

Хонг Конгийн их сургуулийн профессорууд Joseph Chan, Ho-Pong To, Elaine Chan нар Женсон зэрэг судлаачдын дэвшүүлсэн өмнөх онолын хүрээ нь арга хэрэгсэл ба зорилго, хүчин зүйл ба үр нөлөө, зэрэг гол концепциудыг хооронд нь ялгаагүй, хольсон, бодит амьдрал дээр хэмжих боломжгүй, зөвхөн эерэг талыг дөвийлгөсөн зэргээр шүүмжилж байсан. Үүний үндсэн дээр тэд 2006 онд өөрсдийн нийгмийн нягтралын хүрээг боловсруулсан байдаг.

¹¹ Social solidarity

¹² Identity and attachment

Тэд нийгмийн нягтралыг тодорхойлсон хамгийн сайн тодорхойлолт нь нийгмийн шинжлэх ухаан дахь бусад үндсэн ойлголтуудын адил дараах хоёр шалгуурыг хангасан байх ёстой гэж үзжээ:

- Хамрах хүрээ нь тодорхой бөгөөд нарийвчилсан
- Энгийн амьдралд хэрэглэх боломжтой.

Эдгээр шалгуурыг хангаснаар нийгмийн нягтралын ойлголтыг эмпирик судалгаанд ашиглах, гол таамаглалуудыг шалгах, нэг соёлын онцлогоос үл хамаарсан ямар ч соёл, нийгэмд ашиглах боломжийг олгоно. Нөгөө талаас энгийн амьдралд хэрэглэх боломжтой гэдэг нь нийгмийн нягтрал нь үргэлжилж буй үйл явц биш харин төлөв байдал юм гэсэн утгыг агуулна.

Ингэснээр нийгмийн нягтрал нь хүмүүс хэрхэн хоорондоо холбогдож байна, үүнд хувь хүмүүсийн бодол сэтгэлгээ хэрхэн нөлөөлж байна, энэ нь ямар зан үйлээр илэрч байна гэдгийг илэрхийлэх утга юм. Нийгмийн нягтралыг тэгэхээр дараах гурван үзүүлэлтээр хэмжихийг тэд санал болгосон:

1. Нийгмийн гишүүд бие биедээ итгэдэг, тусалдаг, хамтардаг байх
2. Тэднийг нэгтгэж байдаг “адилсал” байх, нийгэмд хамаарч буйг мэдэрч байх
3. Субъектив мэдрэмж нь тэдний объектив зан үйл, үйлдлээр илэрдэг байх.

Эдгээрийг тайлбарласны дараа Чан нар нийгмийн нягтралыг тодорхойлохдоо (Chan, To and Chan 2006):

Нийгмийн нягтрал бол нийгмийн гишүүд хоорондын итгэлцэл, хамаарахуй, оролцоо, дэмжлэг зэрэг үнэлэмж, хэм хэмжээнээс бүрдэж тодорхой зан үйлээр илэрч байдаг, нийгмийн гишүүдийн босоо болон хэвтээ харилцан үйлдлийн аль алиныг багтааж байдаг нийгмийн төлөв байдал юм.

Үүнд нийгмийн гишүүд гэдэгт зөвхөн хувь хүмүүс биш мөн бүлэг, байгууллага, институциудыг багтааж байдаг.

Дүгнэлт

Нийгмийн нягтралын орчин үеийн онолуудыг судалж, харьцуулсны үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Нийгмийн нягтрал бол нийгмийн эв нэгдэл, интеграци, амьдралын чанар зэрэг ойлголтоос ялгаатай бие даасан ойлголт юм.
2. Нийгмийн нягтрал нь хүмүүс хэрхэн хоорондоо холбогдож байна, үүнд хувь хүмүүсийн бодол сэтгэлгээ хэрхэн нөлөөлж байна, энэ нь ямар зан үйлээр илэрч байна гэдгийг илэрхийлэх утга юм.
3. Нийгмийн нягтрал нь олон янз байдал, олон ургальч үзэл, бүтээлч байдал гэх мэт нийгэм дэх өөр олон янзын үнэлэмжийн нэг болдог. Энэ утгаар нь зарим судлаачид хэрэглэдэг.
4. Нийгмийн нягтрал нь нийгмийн гишүүдийн сайн дурын, эрх чөлөөт харилцаан дээр суурилдаг. Албадлагаар бий болсон хамтын ажиллагаа, харилцан туслах байдлыг нийгмийн нягтралд хамруулахгүй.
5. Нийгмийн нягтрал нь нийгмийн гишүүд хоорондоо адилхан байхыг шаарддаггүй. Харин ялгаатай байж, бие биеэ хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх байдлыг илэрхийлдэг.
6. Нийгмийн нягтралын онолуудын гол дутагдал бол түүнийг тодорхойлсон үзүүлэлтүүд нь хоорондоо хэрхэн харилцан холбогдож байгаа нь тодорхойгүй, хоёрдугаарт, зорилго ба арга хэрэгслийг хооронд нь хольсон байдаг.
7. Хэдийгээр нийгмийн нягтралын талаар хангалттай хэмжээний бүтээл, судалгаа хийгдсэн ч өнөөг хүртэл нийгмийн нягтрал гэж юу болох, юуг хэмжих нь тодорхойгүй, нэгдсэн ойлголт бий болоогүй хэвээр байна (Jenson 1998; Jeannotte 2000; Osberg 2003). Зарим нэг нь нийгмийн нягтрал гэдгээр эв нэгдэл, итгэлцэл, нийгмийн капитал, ядуурал, тэгш бус байдал зэргийг

ойлгодог бол зарим нь, ялангуяа социологичид уг ойлголтоор нийгмийн интеграци, системийн интеграцийг илэрхийлдэг (Gough and Olofsson, 1999).

Ном зүй

- Beauvais, C., & Jenson, J. (2002). Social Cohesion: Updating the State of the Research. *CPRN Discussion Paper(F22)*.
- Broad, R. (2006). Research, Knowledge, and the Art of ‘Paradigm Maintenance’: The World Bank’s Development Economics Vice-Presidency (DEC) . *Review of International Political Economy, 13(3)*, 387-419.
- Chan, J., To, H.-P., & Chan, E. (2006). Reconsidering Social Cohesion: Developing a Definition and Analytical Framework for Empirical Research. *Social Indicators Research, 75*, 273–302.
- Dickes, P., Valentova, M., & Borsenberger, M. (2010). Construct Validation and Application of a Common Measure of Social Cohesion in 33 European Countries. *Social Indicators Research, 98*, 451–473.
- Fish, S. M. (1998). Mongolia: Democracy Without Prerequisites. *Journal of Democracy, 127-141*.
- Gore, C. (2000). The Rise and Fall of the Washington Consensus as a Paradigm for Developing Countries. *World Development, 28(5)*, 789-804.
- Jeannotte, M. S. (2008). Promoting Social Integration – A Brief Examination of Concepts and Issues. *Experts Group Meeting*. Helsinki, Finland.
- Oleunik, A. (2012). Institutional Exclusion As a Destabilizing Factor: The Mass Unrest of 1 July 2008 in Mongolia. *Central Asian Survey, 1-22*.
- Reeskens, T. (2008). Defining Social Cohesion in Diverse Societies: How Generalized Trust Relates to Social Cohesion. *Research Day of the Faculty of Social Sciences*.
- Rossabi, M. (2005). *Modern Mongolia: from khans to comisars to capitalists*. University of California Press.
- Shamit Saggar, W. S. (2012). *THE IMPACTS OF MIGRATION ON SOCIAL COHESION AND INTEGRATION*. Final report to the Migration Advisory Committee.
- Stanley, D. (2003). What Do We Know about Social Cohesion: The Research Perspective of the Federal Government's Social Cohesion Research Network. *The Canadian Journal of Sociology, Vol. 28(1)*, 5-17.
- UNDP. (2012). *Хөгжлийн Хэлэлцүүлэг 2: Ядуурал Монгол Улсад: Тоо баримтын цаана*. Retrieved May 4, 2014, from [www.undp.org](http://www.mn.undp.org/content/dam/mongolia/DevelopmentDialogues/DD2013/DD2/Dialogue%20Report%20-%20DD2_MN.pdf):
http://www.mn.undp.org/content/dam/mongolia/DevelopmentDialogues/DD2013/DD2/Dialogue%20Report%20-%20DD2_MN.pdf
- МУИС Социологи-Нийгмийн ажлын тэнхим. (2013). *Монголын нийгмийн судалгаа*. Тэнхимийн дадлагын судалгааны үр дүн.
- О.Мөнхбат. (2008). *Социологийн онол: Сонгодог хийгээд орчин үе*. Улаанбаатар.
- Х.Гүндсамбуу. (2002). *Монголын нийгмийн давхраажил, хөгжил, хандлага (XX зуун)*. Улаанбаатар.
- Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM), АХБ. (2012). *Том оврын машины жолооч нарын судалгаа*. Судалгааны тайлан, Улаанбаатар.
- Ц.Пүрэв. (2013). *Монголын нийгмийг социологиор шинжлэхүй*. Улаанбаатар: МУШУА- Философи, социологи,эрхийн хүрээлэн.
- Ш.Оюунханд. (2005). Нийгмийн хөгжлийг соёл иргэншлийн онолоор тайлбарлахуй. *Социологи, 389(26)(5)*, 28-32.